



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



**МАЛЫН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭДИЙГ
БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ
САНХҮҮЖИЛТ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ**

2025 он

МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ САНХҮҮЖИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ¹

Энэхүү санхүүжилт, үйл ажиллагааны ерөнхий зөвлөмжийг Монгол Улсын ноос, ноолуур, арьс ширний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх салбаруудын танилцуулга, ХХААХҮЯ, Монголын Арьс Ширний Холбоо, Монголын Ноос, Ноолуурын холбоодын санал, зөвлөмж, Монголбанкнаас боловсруулсан салбарын судалгаа, мэргэжилтнүүдийн санал зөвлөмж, олон улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн туршлага зэрэгт үндэслэн боловсруулав.

Зөвлөмж нь Монголбанкны мэргэжилтнүүдийн бүтээл бөгөөд тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт зэрэг нь Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй. Энэ зөвлөмжид тусгагдсан бусад байгууллагуудын мэдээ мэдээллийн үнэн бодит эсэхэд Монголбанк баталгаа өгөхгүй.

Монголбанк нь өөрийн ажлыг түгээн дэлгэрүүлэхийг дэмждэг бөгөөд хэсэгчлэн хэвлэн тараах зөвшөөрлийг шуурхай олгоно.

Боловсруулсан:

Б.Ананд /Ахлах эдийн засагч, Монголбанк, anand.b@mongolbank.mn/

Б.Баттөмөр /Эдийн засагч, Монголбанк, battumur.b@mongolbank.mn/

Б.Бат-Оргил /Эдийн засагч, Монголбанк, batorgil.ba@mongolbank.mn/

Ч.Хурцболд /Эдийн засагч, Монголбанк, khurtsbold.ch@mongolbank.mn/

©МОНГОЛБАНК 2025

¹ Монгол Улсын ноос, ноолуур, арьс ширний зах зээлийн үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, үйл ажиллагааны ерөнхий зөвлөмж

АГУУЛГА

I. НООС, НООЛУУР, АРЬС ШИРНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	7
1.1 Өнөөгийн нөхцөл байдал	7
II. МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	17
2.1 Энэтхэг улс: Ноосны салбарын хөгжлийг дэмжих үндэсний нэгдсэн хөтөлбөр 2021–2026	17
2.2 Австрали улс: Австралийн ноосны тогтвортой байдлын схем (АНТБС)	19
2.3 БНХАУ: 14 дүгээр таван жилийн төлөвлөгөө	20
III. ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ	21
3.1 Цагаан алт үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл	21
3.2 Цагаан алт үндэсний хөтөлбөрийн зорилго	22
3.3 Цагаан алт үндэсний хөтөлбөрийн үндсэн чиглэл	22
3.4 Цагаан алт үндэсний хөтөлбөрийн зорилт	22
3.5 Цагаан алт үндэсний хөтөлбөрийн санхүүжилт	23
3.6 Цагаан алт үндэсний хөтөлбөрийн хүрэх үр дүн	23
IV. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОНОВЧТОЙ ШИЙДЛИЙН ТАЛААРХ САНАЛ	24
4.1 Үйл ажиллагаа, зохион байгуулалт	24
4.2 Хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий санал	25
4.3 Ноолуурын салбарын санхүүжилтийн схем	27
4.4 Ноосны салбарын санхүүжилтийн схем	28
4.5 Арьс ширний салбарын санхүүжилтийн схем	29
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл (2021	11
Хүснэгт 2. Боловсруулсан арьс ширний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гол нэр төрлөөр	14
Хүснэгт 3. Австрали улсын ноосны чанарын баталгааны тэмдэгт тавигдах шалгуур	20
Хүснэгт 4. Ноос, ноолуурын салбарт олгох санхүүжилтийн ерөнхий нөхцөл	27
Хүснэгт 5. Ноос, ноолуурын салбарт олгох санхүүжилтийн ерөнхий нөхцөл	29
Хүснэгт 6. Арьс ширний салбарт олгох санхүүжилтийн ерөнхий нөхцөл	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Экспортын ноолуурын дундаж үнэ	7
Зураг 2.	Ноолуурын дотоодын үнэ, шат дамжлага бүрээр	7
Зураг 3.	Ноолуурын дотоодын үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт, шат дамжлага бүрээр, 2022 он	8
Зураг 4.	Ноолуурын түүхий эдийн болон боловсруулсан үнэ, ам.доллар/кг	9
Зураг 5.	Ноолуурын салбарын нэмүү өртөг бүтээх боломж, шат дамжлага бүрээр	10
Зураг 6.	Угаах үйлдвэрлэлийн хонины ноос ашиглалтын харьцаа, мян.тн.....	12
Зураг 7.	Ноосны түүхий эдийн болон боловсруулсан үнэ, ам.доллар/кг	12
Зураг 8.	Угаах үйлдвэрлэлийн тэмээний ноос ашиглалтын харьцаа, мян.тн	13
Зураг 9.	Угаах, самнах, ээрэх, нэхэх, сүлжих (хувь)	13
Зураг 10.	Хивс, нэхээсгүй эдлэл, дулаалга (хувь)	13
Зураг 11.	Арьс ширний түүхий эдийн болон боловсруулсан үнэ, ам.доллар/кг	15
Зураг 12.	Боловсруулсан арьс ширний экспорт, дүнд эзлэх хувиар.....	16
Зураг 13.	Энэтхэг улсын ноосны салбарыг дэмжих хөтөлбөрийн зорилтууд	18
Зураг 14.	Энэтхэг улсын ноосны салбарын дэмжих хөтөлбөрийн зардлын бүтэц	18
Зураг 15.	"Цагаан алт" үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийн төлөвлөгөө, тэрбум төгрөг	23
Зураг 16.	Удирдлага, зохион байгуулалтын ерөнхий схем	24
Зураг 17.	Санхүүжилтийн ерөнхий схемийн санал	26
Зураг 18.	Ноолуурын салбарт олгох санхүүжилтийн схем	28
Зураг 19.	Арьс ширний салбарт олгох санхүүжилтийн схем	30

ХУРААНГУЙ

Монгол Улс 2022 оны байдлаар дэлхийн ноосны хэрэглээний 0.51 хувийг, түүхий арьс ширний 0.03 хувийг, түүхий ноолуурын 45 хувийг хангаж байна. Эсрэгээр БНХАУ дэлхийн ноосны нийт импортын 65.7 хувийг, арьс ширний 15 хувийг эзэлж байгаа нь Монгол Улсыг малын гаралтай түүхий эдийн экспортоо нэмэгдүүлэх газар зүйн таатай байршилд байгааг илтгэж байгаа юм. Гэтэл Монгол Улсын хувьд ноосны үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт угаах үйлдвэрийнх 41 хувь, самнах үйлдвэр 51 хувь, ээрэх 46 хувь, сүлжих, нэхэх үйлдвэр 48 хувь, хивсний үйлдвэр 45 хувь байгаа юм. Харин ноолуурын салбарын хувьд угаасан ноолуурын 70–75 хувийг шууд экспортод гаргадаг бөгөөд угаах, самнах үйлдвэрлэлийн хүчин чадал хангалттай түвшинд байгаа ч ээрмэлийн үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал түүхий эдтэй харьцуулахад 30 орчим хувь байгаа зэрэг асуудлууд хэвээр байна.

Малын гаралтай түүхий эд нь боловсруулалтын шат дамжлага олон, дамжлага бүрд шингэх нэмүү өртөг өндөр байдаг онцлогтой тул БНХАУ, Австрали, Энэтхэг зэрэг энэ төрлийн салбар эрчимтэй хөгжиж буй улсууд гүн боловсруулах чиглэл рүү хөрөнгө оруулалт ихээр хийж, түүхий эд бэлтгэлийн стандарт болон бүтээгдэхүүний чанарт ихээр анхаарах болсон. Жишээлбэл, түүхий ноолуурын дэлхийн зах зээл дээрх үнэ нэг килограмм нь 50–100 ам.доллар байдаг бол боловсруулалт хийгдсэнээр 200–250 ам.долларт хүрдэг, арьс ширний салбарын нэмүү өртгийн потенциал малын гаралтай түүхий эдийн зах зээл дундаас хамгийн өндөр байдаг гэх мэт олон давуу талыг ашиглан экспортын орлогоо хурдацтай нэмэгдүүлж байгаа юм.

Монгол Улсын хувьд байгалийн эрс тэс уур амьсгалаас шалтгаалан хамгийн дээд зэрэглэлийн ноолууруудын нэгийг бэлтгэдэг, ноос болон арьс ширний түүхий эдийн асар их нөөцтэй боловч түүхий эд бэлтгэлийн шатанд стандарт хангалтгүй, боловсруулалтын шатанд технологийн хүчин чадал дутмаг зэрэг асуудлууд нь салбарын хөгжлийг хойш татсаар байна.

Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, экспортын орлогыг өсгөх, салбарын нэгдсэн стандарт, хууль эрх зүйн орчныг таатай болгох, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас «Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай» тогтоолыг 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталж, "Цагаан алт" үндэсний хөтөлбөрийг 2024–2028 оны хооронд хэрэгжүүлэхээр болсон.

Энэхүү ажлаар "Цагаан алт" үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлж болох Монгол Улсын малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшин, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны болон санхүүжилтийн оновчтой шийдлийг боловсруулахыг зорилоо.


1. НООС, НООЛУУР, АРС ШИРНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1 ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1.1 Ноолуурын салбарын хураангуй:


Дэлхийн ноолуурын зах зээлд жилд дунджаар 24 мянган тонн ноолуур бэлтгэгддэг бөгөөд үүний 50 хувийг (12 мянган тонн) БНХАУ, 40 хувийг (9.6 мянган тонн) Монгол Улс нийлүүлдэг. Түүхий ноолуурыг угаах, самнах, ээрэх, нэхэх шат дамжлагаар боловсруулж сүлжмэл болон оёдлын үйлдвэрүүд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Монгол Улсад сүлжмэлийн үйлдвэрлэл давамгайлж, энэ төрлийн бүтээгдэхүүний экспорт нь улсын ноолуурын орлогын ихээхэн хэсгийг бүрдүүлдэг. Нэмүү өртөг шингээх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 19 дүгээр тогтоолоор хялгас ялгах аас дээш шатны боловсруулалт хийсэн ноолуурыг экспортлох тухай тогтоол баталсан боловч хэрэгжүүлэх хугацааг хойшлуулснаар бодит үр дүн гарч эхлээгүй байна. Өнөөгийн байдлаар угаасан ноолуурын 70–75 хувь нь шууд экспортод гардаг ба хэрэв самнах шат дамжлагыг Монголд хийвэл экспортын орлого 300 сая ам.доллараар нэмэгдэх боломжтой. Цаашлаад ээрэх шат дамжлагыг дотоодод хийвэл салбарын экспортын орлого 3.4 дахин өсөх боломжтой юм.

Зураг 1. Экспортын ноолуурын дундаж үнэ



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 2. Ноолуурын дотоодын үнэ, шат дамжлага бүрээр



Эх сурвалж: ХХААҮЯ

Салбарын хүндрэл: Ноолуурын салбарын үйлдвэрлэлийн шат дамжлагад дараах хоёр асуудал үүсэж байгаа нь салбарын хөгжлийг дараагийн түвшинд хүргэхэд саад учруулж байна.

1. Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид эргэлтийн хөрөнгө хүрэлцээгүй, эргэлтийн хөрөнгийн зээлийн хугацаа богино, хүү өндөр байдгаас шалтгаалан хаврын ноолуур бэлтгэлийн үед


хангалттай хэмжээний түүхий эд нөөцөлж авч чаддаггүй.

2. Ээрмэлийн үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын хүрэлцээгүй байдлаас үүдэн эцсийн бүтээгдэхүүн боловсруулах түүхий эд буюу ээрмэл утас байнгын хомсдолтой байдаг.

Нэгдүгээр асуудлын хувьд, УИХ-ын баталсан тогтоолын дагуу самнахаас дээш шатны боловсруулалт хийгдсэн ноолуурыг экспортлох тогтоол хэрэгжиж эхлээгүйгээс шалтгаалан угаасан ноолуурын экспорт өндөр хэвээр байгаа нь дараах шалтгаантай байна. Монгол Улсын хэмжээнд ноолуурын түүхий эд бэлтгэл хавар буюу ихэвчлэн 3 дугаар сараас эхлэн явагддаг бөгөөд дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид эргэлтийн хөрөнгийн санхүүжилт дутмаг, зээлийн шийдвэр оройтож гарах зэргээс шалтгаалан БНХАУ-ын бизнес эрхлэгчид түүхий ноолуурыг малчдын гар дээрээс урьтаж худалдаж аван, угаасан хэлбэрээр экспортод гаргах, БНХАУ-ын бизнес эрхлэгчид Монголд худалдан авалт хийсэн ноолууртаа зохих хэмжээний татварыг төлдөггүй учир илүү өндөр үнэ малчдад санал болгох зэрэг шалтгаануудаас үүдэн хаврын түүхий эд бэлтгэл хангалттай хэмжээнд хийгддэггүй.

Хоёрдугаар асуудлын хувьд, Монгол Улсын хэмжээнд ээрэх үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал жилд бэлтгэгдэж буй түүхий эдтэй харьцуулахад дөнгөж 30 хувь хүрч байгаа (үүнээс Говь ХК-аас бусад үйлдвэрүүд 15 хувь орчим) нь сүлжмэлийн үйлдвэрүүдийн ээрмэл утасны эрэлтийг хангах боломжгүй, улмаар экспортод гарах эцсийн бүтээгдэхүүний хэмжээ болон орлогод сөргөөр нөлөөлж байгаа юм.

Зураг 3. Ноолуурын дотоодын үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт, шат дамжлага бүрээр, 2022 он



Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо

Одоогийн суурилагдсан тоног төхөөрөмжийн хүчин чадал ашиглалтыг харвал угаах үйлдвэр хамгийн өндөр буюу бүх түүхий ноолуураа дотооддоо угаахад хангалттай хэмжээний хүчин чадал


бүхий тоног төхөөрөмж суурилагджээ. Харин самнах болон ээрэх үйлдвэрүүд 2022 оны байдлаар 30 хувийн л ашиглалттай байна. Дээрх зураг 3 дээрх потенциал түүхий эдийн хэмжээ гэдэг нь манай улс бэлтгэсэн бүх ноолуураа эцсийн бүтээгдэхүүний шат хүртэл боловсруулах тохиолдолд үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээс гарах хэмжээг илэрхийлсэн. Үүнийг одоогийн суурилагдсан тоног төхөөрөмжийн хүчин чадалтай харьцуулан харвал самнах үйлдвэрийн хувьд 88 хувийг, ээрэх үйлдвэрийн хувьд 50 орчим хувийг л боловсруулах боломжтой байна (Зураг 3). Өөрөөр хэлбэл, самнах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дутагдал харьцангуй бага бол ээрэх үйлдвэрийн хувьд багагүй хэмжээний тоног төхөөрөмжийн дутагдалтай гэж дүгнэж болох юм.

Шигтгээ 1. Ноолуурын салбарын түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний үнийн ялгаа

Ноолуур нь эрс тэс уур амьсгалтай улсуудад ямаанаас гарган авдаг ховор, үнэтэй материал гэдгээр онцлогтой. Дэлхийн ноолуурын үйлдвэрлэлд БНХАУ, Монгол улсууд голлон тэргүүлдэг.

- **БНХАУ** нь дэлхийн ноолуурын нийлүүлэлтийн 60 хувийг дангаараа бүрдүүлдэг бөгөөд боловсруулсан ноолуурын чанараас илүүтэйгээр масс үйлдвэрлэлд анхаардаг. БНХАУ-ын боловсруулсан ноолуурын экспорт 2023 онд 3.6 тэрбум ам.доллар байв. Боловсруулаагүй ноолуурын үнэ 50–100 ам.доллар/кг байдаг бол боловсруулсан ноолуурын үнэ 200–250 ам.доллар/кг хүрдэг.
- **Монгол Улс** нь ноолуурын хоёрдогч том үйлдвэрлэгч бөгөөд дээд зэргийн ноолуурыг нийлүүлдгээрээ онцлогтой. Манай Улсын эрс тэс уур амьсгал нь зөөлөн, сайн чанарын ноолуурыг гарган авахад голлон нөлөө үзүүлдэг. Ноолуурыг гар аргаар самнан авч, экспортын дийлэнхийг боловсруулаагүй байдлаар экспортолдог. Манай Улсын ноолуурын экспорт 2023 онд боловсруулаагүй 376 сая, боловсруулсан 39 сая ам.доллар байв. Боловсруулаагүй ноолуурын үнэ 50–80 ам.доллар/кг байдаг бол боловсруулсан ноолуурын үнэ 150–480 ам.доллар/кг болдог.


Зураг 4. Ноолуурын түүхий эдийн болон боловсруулсан үнэ, ам.доллар/кг



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газрын статистикийн эмхэтгэл, Ноолуурын үнийн статистик, БНХАУ-ын нэхмэлийн цахим хуудас

Манай улсын ноолуурын экспорт 2011 оноос хойш өссөн ч угаасан болон самнасан ноолуурын харьцаа өөрчлөгдөөгүй². Монгол Улс дэлхийн ноолуурын 40 орчим хувийг бэлтгэдэг ч дотооддоо 20 хүрэхгүй хувийг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглаж, ихэнхийг нь анхан шатны боловсруулалт хийн экспортолдог³. Монголбанкны судалгаагаар, бүх ноолуурыг эцсийн бүтээгдэхүүн болгож экспортолдог бол жилд 1.5 тэрбум ам.долларын валютын урсгал нэмэгдэх боломжтой гэж тооцоолжээ (Зураг 5).

Зураг 5. Ноолуурын салбарын нэмүү өртөг бүтээх боломж, шат дамжлага бүрээр



Эх сурвалж :Б.Эрхэмбаяр, Н.Янжинлхам. (2023). Монгол Улсын ноолуурын салбарын төлөв байдал, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл. Монголбанк., ХХААХҮЯ, МННХ.

Ноолуурын боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх талаар Монгол Улсад хийгдсэн судалгааны ажлуудын зөвлөмж, саналуудыг дурдвал:

Арилжааны банкууд ноолуурын салбарт төрийн дэмжлэгтэй зээлээс бусад санхүүжилт олгох сонирхол бага байна. Иймд төрөөс хүүний татааснаас гадна тогтвортой санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх, технологийг сайжруулах, олон улсын зах зээлд сурталчлах чиглэлд анхаарах хэрэгтэй гэж үзжээ (Эрхэмбаяр, Б., Янжинлхам, Н., 2023).

² Нийт экспортолж буй ноолуурын ердөө 10 орчим хувь нь самнасан ноолуур байна.

³ Монгол Улсын ноолуурын салбарын төлөв байдал, Мөнгөний бодлогын газар, Монголбанк, 2023 он.

- Мөн тус судалгаанд богино хугацааны шийдлийн хувьд ААН-үүдийн одоогийн ашиглаж буй барилга, үл хөдлөх хөрөнгө нь шаардлагатай санхүүжилтийн барьцаа болж чадахгүй байгаа тул ААН-үүдэд очих зээлийг өсгөхийн тулд барьцаа хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ. Тухайлбал, (i) хөдлөх хөрөнгө буюу ноолуурыг барьцаалах, (ii) зээлийн батлан даалтад хамруулах зэрэг боломжийг эрэлхийлэх зэргээр барьцаа хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлж болох юм. Хэрэв тийм боломжийг нээвэл банкууд ноолуурын салбарыг сонирхдог, тус салбарт зориулсан бүтээгдэхүүнийг хөгжүүлж, ноолуурын компаниудтай хамтран ажилладаг болж, илүү тогтвортой санхүүжилтийн схем бий болох боломжтой гэж үзжээ.

Ноолуурын салбарыг хөгжүүлэхийн тулд ноолуурын чанарыг сайжруулах, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог оновчтой болгох, угаасан ноолуурын экспортыг бууруулж, боловсруулсан ноолуурын экспортыг дэмжих, Монгол ноолуурын брэндийг олон улсад сурталчлах бодлого хэрэгтэй гэж зөвлөжээ (Эрхэмбаяр, Б., Янжинлхам, Н., 2023).

1.1.2 Ноосны салбарын хураангуй:

Хүснэгт 1. Ноос боловсруулах салбарын үйлдвэрлэл (2021)

Ноос угаах	Хялгас ялгах буюу самнах	Ээрэх ба будах	Эцсийн бүтээгдэхүүн
28 үйлдвэр	23 үйлдвэр	9 үйлдвэр	Хивсний-2
			Нэхэх үйлдвэр-4
			Сүлжих-56
			Нэхээсгүй эдлэл-1
			Эсгий эдлэл-16

Эх сурвалж: ХХААХҮЯ

Ноос боловсруулалт нь малчдаас түүхий ноос бэлтгэхээс эхлээд угаах, хялгас ялгах буюу самнах, ээрэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх (хивс, сүлжих гэх мэт) шат дамжлагаас бүрддэг. Монгол Улсад жилд дунджаар 38,000 тонн бохир ноос бэлтгэгддэг бөгөөд үүнээс ойролцоогоор 18,000 тонн угаасан ноос гардаг (тодорхой хэмжээний түүхий эд агуулахын үлдэгдэл, хаягдал болдог ба угаах явцад жингээ алддаг). Үүнээс 15,000 гаруй тонн нь самнаагүй хэлбэрээр экспортлогдож, 280 сая ам.долларын орлого олдог. Үлдсэн угаасан ноос нь самнах, ээрэх зэрэг гүн боловсруулалтад ашиглагддаг бөгөөд ихэнх нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шилждэг. Эцсийн бүтээгдэхүүнүүд нь хивс, ноосон оймс, сүлжмэл эдлэлүүд бөгөөд ихэвчлэн дотоодын зах зээлд борлуулагдаж, бага хэмжээний бүтээгдэхүүнийг экспортолдог.

Зураг 6. Угаах үйлдвэрлэлийн хонины ноос ашиглалтын харьцаа, мян.тн



Эх сурвалж: ҮСХ, ХҮБХЗГазар ХХААҮЯ (2022)

Шигтгээ 2. Ноосны салбарын түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүний үнийн ялгаа

Ноос нь байгалийн гаралтай, олон талын ашиг, тустай бүтээгдэхүүн бөгөөд ширхэг бүрээр нэгэндээ наалдаж хоорондын завсартаа агаар агуулдаг онцлог нь дулаан хадгалах нөхцөлийг бүрдүүлдэг. Ноосны үйлдвэрлэлд түүхий эд нийлүүлэгч гол улсууд нь Австрали, БНХАУ, Шинэ Зеланд юм.

- Австрали Улс нь дэлхийн ноосны үйлдвэрлэлд тэргүүлэх байрыг буюу дангаараа 25 хувийг бүрдүүлдэг байна. Тус улсын зөөлөн, нарийн ширхэгтэй, удаан эдэлгээтэй Мерино төрлийн ноос нь онцлог. Мерино ноосны түүхий эдийн үнэ 2–4 ам.доллар/кг байдаг бол боловсруулсан ноосны үнэ чанараасаа шалтгаалж 5–11 ам.доллар/кг болдог.
- БНХАУ нь дэлхийн ноосны 18 хувийг бүрдүүлдэг бөгөөд өөрийн улсын томоохон нэхмэл үйлдвэрүүдэд түүхий ноосыг импортлож ашигладаг. Түүхий ноосны үнэ 1.5–3 ам.доллар/кг байдаг бол боловсруулсан ноосны үнэ 4–8 ам.доллар/кг болдог.
- Шинэ Зеланд Улс нь эрлийзжүүлсэн хонины ноосоороо онцлог бөгөөд дэлхийн ноосны үйлдвэрлэлийн 11 орчим хувийг бүрдүүлдэг. Ноосны ширхэг нь харьцангуй бүдүүн, том ширхэгтэй байдаг тул хивс, бүрээс хийхэд түлхүү ашигладаг. Тус төрлийн түүхий ноосны үнэ 2–5 ам.доллар/кг байдаг бол боловсруулсан ноосны үнэ 6–12 ам.доллар/кг болдог байна.

Зураг 7. Ноосны түүхий эдийн болон боловсруулсан үнэ, ам.доллар/кг



Эх сурвалж: Олон Улсын Ноос Нэхмэлийн байгууллага

Зураг 8. Угаах үйлдвэрлэлийн тэмээний ноос ашиглалтын харьцаа, мян.тн




Эх сурвалж: YCX, ХҮБХЗГазар ХХААҮЯ (2022)

Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт: Үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал үйлдвэрлэлийн төрлөөсөө хамааран 2022 оны байдлаар 5–61 хувийн ашиглалттай байсан байна. Энэхүү хүчин чадлын ашиглалтыг авч үзвэл угаах 41 хувь, самнах 51 хувь, ээрэх 46 хувь, нэхэх 23 хувь, хивс 45 хувь, нэхээсгүй эдлэл 57 хувь, эсгий 61 хувь, ноосон дулаалгын материал 5 хувийн ашиглалттай байна.

Зураг 9. Угаах, самнах, ээрэх, нэхэх, сүлжих (хувь)



Зураг 10. Хивс, нэхээсгүй эдлэл, дулаалга (хувь)



Эх сурвалж: ХҮБХЗГазар ХХААҮЯ (2022)

1.1.3 Арьс ширний салбарын хураангуй:

Монгол Улсын арьс ширний салбар нь боловсруулах үйлдвэрлэлийн анхдагч салбаруудын нэг бөгөөд 1990 оноос малын арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүнийг экспортолж эхэлсэн. 5 хошуу малын арьсыг гутал, бээлий, хувцас, малгай зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор хагас болон гүн боловсруулдаг. Одоогоор арьс боловсруулах чиглэлээр 34 үйлдвэр (Хан-Уул дүүрэгт 30

орчим үйлдвэр, Баянгол дүүрэгт 2 үйлдвэр, Дархан-Уул аймагт 2 үйлдвэр) үйл ажиллагаа явуулж байгаа бол арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 100 гаруй үйлдвэр, 4000 орчим хувь хүн тус салбарт ажиллаж байна (Монголын Арьс Ширний Холбоо). Түүхий эд бэлтгэлийн 70–75 хувь нь 8–11 дүгээр сард явагддаг бол боловсруулах үйлдвэрлэлийн химийн орцыг 4–8 дугаар сард татан авдаг байна.

Салбарын хүндрэл:

- **Түүхий эд нийлүүлэгчид:** Монгол Улсад гарсан малын гоц халдварт өвчнүүд болон малын халдваргүйжүүлэлтийн хяналт сул байгаагаас болж БНХАУ манай улсаас салаа туурайт малын түүхий арьс, шир импортлохыг зогсоосон. Энэ нь малчдын түүхий арьс, ширний үнэ огцом буурахад хүргэсэн.
- **Хагас болон гүн боловсруулагчид:** Мах бэлтгэлийн үйлдвэрүүд болон малчид дайвар бүтээгдэхүүн болох арьс, ширийг арьс ширний үйлдвэрүүдэд нийлүүлэхдээ хойрго хандаж, нядалсны дараа чанарыг хамгаалах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй. Үүнээс болж түүхий эдийн чанар муудаж, үйлдвэрийн гологдол бүтээгдэхүүн ихэсдэг. Мөн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ихэнх нь жижиг дунд үйлдвэр (ЖДҮ) тул тогтвортой ажиллаж чадахгүй, хязгаарлагдмал зах зээлийг үүсгэдэг.
- **Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид:** Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгийн хүрэлцээгүй байдал нь үйлдвэрлэлийн шат дамжлагад сөргөөр нөлөөлдөг. Мөн ихэнх нь ЖДҮ тул зээл авахад барьцаа хөрөнгө дутагдаж үйл ажиллагаагаа тэлж чаддаггүй.

Хүснэгт 2. Боловсруулсан арьс ширний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гол нэр төрлөөр

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022
Хром, булигаар	мян.м2	80.1	131.4	4.3	0.4	0.8
Савхин цүнх	мян.ш	39.3	18.9	7.8	13.0	7.9
Савхин гутал, ботинк	мян.хос	40.5	38.6	53.5	35.7	58.0
Савхин дээл, хүрэм	мян.ш	12.6	17.1	9.8	9.9	3.4
Нэхий дээл	мян.ш	9.9	12.9	7.6	9.4	17.0

Эх сурвалж: ҮСХ

Шигтгээ 3. Арьс ширний салбарын түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний үнийн ялгаа

- Бразил Улс нь арьс ширний томоохон үйлдвэрлэгч орон бөгөөд голлон үхрийн боловсруулсан арьсыг Европ, Ази тивүүдэд экспортолдог. Арьс ширний түүхий эдийн үнэ нь 4–6 ам.доллар/кг байдаг бол боловсруулснаар 10–16 ам.доллар/кг хүрдэг. Боловсруулсан арьсаар хийсэн гутал, цүнхний үнэ нь бусад орнуудтай харьцуулахад хямд байдаг.
- БНХАУ нь голлон үхрийн арьсан түрийвч, гутал, хувцсыг масс хэмжээгээр үйлдвэрлэдэг. Боловсруулаагүй арьс ширний үнэ 7–11 ам.доллар/кг байдаг бол боловсруулснаар 13–22 ам.доллар/кг байна.
- Итали Улс нь дээд зэргийн арьсан цүнх, гутал, тавилгын бүрээс зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Боловсруулаагүй арьс ширний үнэ 11–22 ам.доллар/кг байдаг бол боловсруулсны дараа 33–66 ам.доллар/кг болж нэмэгддэг. Боловсруулалтад дотоодын үхрийн арьс ашигладаг ч, тоо хэмжээ болон чанарын асуудлаас болж Бразил, Америк, Франц зэрэг орнуудаас сайн чанарын боловсруулсан арьс импортлон, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг.

Зураг 11. Арьс ширний түүхий эдийн болон боловсруулсан үнэ, ам.доллар/кг



Эх сурвалж : World Food & Agriculture Prices. Selina Wamucii.

Салбарын хүчин чадал: Монгол Улс жилд дунджаар 10 сая ширхэг арьс, ширэн түүхий эдийн нөөц бэлтгэж байгаа бөгөөд үүний 2 сая гаруйг нь гүн боловсруулж, 5 сая гаруйг нь хагас боловсруулж, үлдсэн нь ашиглагдахгүй байна. Тухайлбал, үхрийн ширний 42 хувь, адууны ширний 2.7 хувийг, тэмээний ширний 95.5 хувийг, хонины нэхийний 45.5 хувь, ямааны арьсны 49 хувийг боловсруулж байна.

Монгол Улс 2013 онд малын арьс, ширний экспортыг зогсоох шийдвэр гаргасан бөгөөд үүнээс хойш арьс, ширний үнэ огцом буурсан. Тухайн үед 8,600 төгрөг байсан хонины нэхий 2,400 төгрөг, 32,000 төгрөг байсан үхрийн шир 5,300 төгрөг, 34,000 төгрөг байсан адууны шир 8,300 төгрөг болж, 10 жилийн хугацаанд түүхий эдийн үнэ 8 дахин буурсан байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын

Засгийн газар 2025 оны нэгдүгээр сараас боловсруулалтад ороогүй арьс, ширийг экспортлохыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж, үнийг өсгөх зорилт тавиад байна. Арьс, шир боловсруулах салбар нь нийт 14.9 сая ширхэг арьс, ширийг хагас боловсруулж, 700 мянган бодын шир, 1.7 сая богийн арьс, ширийг гүн боловсруулах хүчин чадалтай байна.

Зураг 12. Боловсруулсан арьс ширний экспорт, дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: Гадаад худалдаа, ҮСХ

Монгол Улсад 2000 оноос арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргэж Улаанбаатар, Дархан хотод арьс шир боловсруулах 34 үйлдвэр, нийслэл, аймаг орон нутагт арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 гаруй жижиг, дунд үйлдвэр ажиллаж байгаа бөгөөд эдгээр арьс шир боловсруулах үйлдвэрүүд жилд бэлтгэж буй түүхий эдийн 40 гаруй хувийг л боловсруулдаг.

Монгол Улс нь өсөн нэмэгдэж буй малын тоо толгойн улмаас арьс ширний салбарт харьцангуй давуу талтай боловч малын өвчлөл, хадгалалт, тээвэрлэлтийн гэмтлээс үүдэн арьс ширний чанар алдагдаж, боловсруулах үйлдвэрүүд чанартай түүхий эдээр хангагдаж чаддаггүй байна. Мөн арьс ширний салбарын хувьд мэргэжлийн ажилчид, болон инженер, химийн чиглэлийн нарийн мэргэжлийн боловсон хүчин нэгэн зэрэг дутагдалд орж, мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо алдагдсан нь хүндрэл үүсгэдэг байна. Арьс ширний салбарт тулгарч буй бэрхшээлүүдийг шийдэж, экспортыг нэмэгдүүлэхийн тулд салбар салбарын боловсруулсан судалгаан дээр үндэслэн дараах санал, зөвлөмжийг боловсруулсан байна:

- Арьс ширний салбарт амьд малын арьсны гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, чанартай түүхий эд бэлтгэх системийг бүрдүүлэх, арьс бэлтгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, арьс шир боловсруулах төвлөрсөн аж үйлдвэрийн парк байгуулах, арьс ширний боловсруулалтыг шат дараатай нэмэгдүүлэх, түгээлтийн сувгуудын хөгжлийг дэмжих (Монголбанк, 2022).

- Түүхий эд бэлтгэлийн системийг боловсронгуй болгох; (2) гадаадад экспортлох болон дотоод зах зээлд бүтээгдэхүүн борлуулалтын суваг нээх; (3) арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэж, шинэ суурьшлын бүсэд арьс ширний үйлдвэрлэл технологийн парк байгуулах; (4) мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийг бэхжүүлэх, (5) бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай (ХХААХҮЯ, 2020)
- Мөн арьс ширний үйлдвэрлэлд тулгарч буй шавжаас үүдэлтэй гэмтлийг багасгахын тулд шавж зайлуулах программыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж тус тус дүгнэжээ (Монгол Улсын ХАА-н салбарын суурь судалгаа, 2017).


2. МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Аливаа улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, стандартыг сайжруулах хөтөлбөрүүд зөвхөн үйлдвэрлэл дэмжих санхүүжилт олгохоос илүүтэй цогц байдлаар хэрэгждэг байна. Салбарын тогтвортой үйлдвэрлэлийг бий болгохын тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн эрхлэгч анхдагч оролцогчоос эхлээд, үйлдвэрлэгч, эцсийн худалдан авагч хүртэлх бүх шатны үйл ажиллагааг цогц байдлаар оновчтой бүрдүүлж өгөх нь хөтөлбөрийн суурь зарчим болох ёстой байдаг. Энэхүү цогц төлөвлөгөөг боловсруулахдаа (i) олон улсад хүлээн зөвшөөрөгдөх үндэсний нэгдсэн стандарт, (ii) нийлүүлэлтийн сүлжээний цогц мэдээллийн систем, (iii) байгаль орчинд ээлтэй байдал, малын эрүүл ахуй, хэрэглэгчдийн эрүүл ахуй зэрэг суурь зарчмуудыг зайлшгүй шингээснээр түүхий эдээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн бий болох үйлдвэрлэлийн бүх шат дамжлагын хувьд чанарын тогтвортой байдал бий болж, борлуулалтын түвшнийг урт хугацаанд өсгөх боломжийг бүрдүүлдэг.

2.1 ЭНЭТХЭГ УЛС: НООСНЫ САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ХӨТӨЛБӨР 2021-2026

Хэрэгжүүлж буй арга хэмжээ: Ноосны салбарын хөгжлийг дэмжих үндэсний нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн 4 чиглэлийг дэмжих үйл ажиллагааг 2026 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан. Өөрөөр хэлбэл энэхүү хөтөлбөрөөр стандартын дагуу ноос бэлтгэх, ноосон эдлэл үйлдвэрлэх, түүнд шаардлагатай хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, өөрсдийн брэнд ноосны төрлийг хөгжүүлэх (Пашмина сортын ноос), салбарын борлуулалтыг өсгөх гэсэн цогц хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа юм.

Зураг 13. Энэтхэг улсын ноосны салбарыг дэмжих хөтөлбөрийн зорилтууд



Эх сурвалж: Ministry of Textiles, India

Санхүүжилтийн схем: Хөтөлбөрийн хүрээнд батлагдсан нийт санхүүжилтийг дараах үндсэн 7 хэсэгт зарцуулахаар төлөвлөсөн нь зөвхөн ноосны аж ахуй эрхлэгчдэд санхүүжилт өгөөд орхих бус, хөтөлбөрийг хэрэгжүүлэх агентлагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, ноос үйлдвэрлэлээс гадна маркетинг, брэнд хөгжүүлэлтэд анхаарах, өмнө хэрэгжиж байсан хөтөлбөрүүдийн өрийн үлдэгдлийг залруулах зэрэг чиглэлүүдэд хуваан зарцуулахаар тусгасан байна.

Зураг 14. Энэтхэг улсын ноосны салбарын дэмжих хөтөлбөрийн зардлын бүтэц



Эх сурвалж: Ministry of Textiles, India

Санхүүжилт: Санхүүжилтийн зарцуулалтад хэд хэдэн хязгаарлалтуудыг тавьж өгсөн. Үүнд, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны зардлын төсөв нь нийт хөтөлбөрийн санхүүжилтийн 2 хувиас хэтрэхгүй байх, хөтөлбөрт шалгарсан төсөл нь авсан санхүүжилтээрээ бүтээн байгуулах үйлдвэрийн барилга байгууламжийн зардал нийт санхүүжилтийн 25 хувиас хэтрэхгүй байх, нэгдүгээр шатны санхүүжилтийн зарцуулалтаа үнэлгээ хийлгэж, шалгуур хангасан тохиолдолд дараагийн ээлжийн санхүүжилтээ авах боломж бүрдэх зэрэг суурь зохицуулалтыг тусгасан.

"Yarn-Bank" схем: Жижиг нэхмэлийн үйлдвэрүүдийн ээрмэл утасны үнийн хэлбэлзлээс хамгаалах санхүүжилтийн хөтөлбөр. Жижиг дунд үйлдвэрлэгч, тэдгээрийн нэгдэл, хоршоо зэрэг 11-ээс олон ажиллагчтай хуулийн этгээдэд хүүгүй санхүүжилт олгох замаар нэхмэлийн утсыг бөөнөөр, хямд үнээр авах боломжоор хангаж, дамлан наймаалалт, орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчдийн нэмэгдэл үнээс зайлсхийх боломж олгодог.

Чанарын баталгааны тэмдэг: Ноосон эдлэлийг чанарын баталгаагаар хангах, брэндинг үүсгэх зорилгоор олон улсад чанарын баталгааны тэмдгийг тодорхой стандарт хангасан бүтээгдэхүүнд олгодог.

2.2 АВСТРАЛИ УЛС: АВСТРАЛИЙН НООСНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СХЕМ (АНТБС)

Австрали улс нь ноосны салбарын чанар, стандартад голчлон анхаардаг. Australian Wool Exchange (AWEX) буюу ноосны бирж байгуулж, долоо хоног бүр каталог байдлаар хамгийн чанартай, стандартад нийцсэн ноосны брэндүүдийг танилцуулдаг тогтолцоо нь ноос, ноосон эдлэл үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд болон түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг холбодог талбар болж чадсан. Энэхүү биржээр дамжуулан худалдан авагч тал хамгийн сайн чанарын ноосыг бүрэн мэдээлэл дээр үндэслэн авах боломж бүрддэг бол ноос нийлүүлэгч фермерүүдийг **SustainaWool** болон **ResponsiWool** гэсэн чанарын стандартуудыг хангуулах замаар ноос худалдан авагчид очих бүх үйл явцын бүрэн мэдээллийг хянах боломжтой болгосон систем юм.

Австралийн хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч фермерүүдийг дэлхийн улс орнуудын брокер, худалдан авагч, үйлдвэрлэгч, брэндүүдтэй холбох схем бөгөөд тогтвортой байдлын хувьд хамгийн өндөр стандартыг баримталдаг, гарал үүслийг чухалчилдаг, үр ашгийг хамгийн өндөр түвшинд байлгах технологийг хэрэгжүүлдэг байх гол зарчмыг баримталдаг.

АНТБС нь ноосны тогтвортой байдлыг хангах хүрээнд дараах зарчмуудад анхаардаг:

- байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглах,
- хонины эрүүл ахуйг хангах,
- үйлчлүүлэгчдийн эрүүл ахуйг хангах,
- үйлдвэрлэлийн технологийн чанар, тогтвортой байдлыг хангах,
- чанарын ноос, мэдээллийн бүрэн бүтэн хяналт хийх

Халдваргүйжүүлэлтдээ хэрэглэж буй химийн бодисоос хамааран шалгуур хангасан ноосны аж ахуй эрхлэгчдэд **SustainaWool** (Тогтвортой ноосны аж ахуй эрхлэгч) болон **ResponsiWool** (Хариуцлагатай ноосны аж ахуй эрхлэгч) гэсэн чанарын сертификат олгодог.

Хүснэгт 3. Австрали улсын ноосны чанарын баталгааны тэмдэгт тавигдах шалгуур

SustainaWool™			ResponsiWool™		
Тогтвортой байдлын шалгуур	Байгаль орчинд ээлтэй	+	Тогтвортой байдлын шалгуур	Байгаль орчинд ээлтэй	+
	Хонины эрүүл мэндэд ээлтэй	+		Хонины эрүүл мэндэд ээлтэй	+
	Үйлчлүүлэгчид ээлтэй	+		Үйлчлүүлэгчид ээлтэй	+
	Салбартаа ээлтэй	+		Салбартаа ээлтэй	+
	Өвчин намдаах тариа хэрэглэдэггүй	+		Стандартын өвчин намдаах тариа хэрэглэдэг	+
Чанарын шалгуур	Стандартын дагуух ноос бэлтгэл	+	Чанарын шалгуур	Стандартын дагуух ноос бэлтгэл	+
	Гарал үүслийн стандарт хангасан	+		Гарал үүслийн стандарт хангасан	+

Эх сурвалж: Australian Wool Sustainability Scheme

Wool classer (Ноосны мэргэшсэн ангилалч): AWEX бирж дээр дуудлага худалдаанд орж буй ноосыг мэргэжлийн ноос ангилалч зэрэг авсан мэргэжилтнээр ангилал тогтоолгож худалдаалах бөгөөд Австралийн Ноос Ангилалчдын Холбооноос үйл ажиллагаа явуулах сертификатаа авдаг байна. Гол зорилго нь биржээр дамжиж буй ноосыг тогтсон нэг стандартын дагуу ангилалд оруулах юм.

Woolclip application: Энэхүү аппликэйшний гол зорилго нь ноосны гарал үүслээс эхлээд нийлүүлэгч, худалдан авагчдын бүрэн мэдээллийг интернэттэй болон интернэтгүй үед системд нэгтгэх бөгөөд оролцогч талуудын мэдээллийн давхардлыг арилгах, аливаа хамтрал, хоршооны мэдээллийг нэгтгэх, механик алдааг бууруулах, нийлүүлэлтийн сүлжээний мэдээллийг бүрэн нэгтгэх зэрэг давуу талуудыг олгодог.

Стандарт: AWEX-ийн Ноосны үйлчилгээний хэлтэс нь салбарын ноос бэлтгэх, ноос худалдаалахтай холбоотой стандартыг боловсруулж мөрдүүлдэг бөгөөд гол зарчим нь Австрали улсад үйлдвэрлэгдсэн ноос дэлхийн стандартыг хангаж байх явдал юм.

2.3 БНХАУ: 14 ДҮГЭЭР ТАВАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БНХАУ-ын 14 дүгээр таван жилийн төлөвлөгөөнд арьс ширний салбарын хөгжлийн зорилтуудыг технологийн шинэчлэл, ногоон үйлдвэрлэлд төвлөрүүлжээ. 2025 он гэхэд ногоон үйлдвэрлэлийн түвшнийг шинэ шатанд хүргэхээр төлөвлөсөн бөгөөд дахин цэвэршүүлсэн усны ашиглалтыг 10 хувиар нэмэгдүүлэх, хром агуулсан хаягдлыг боловсруулах туршилтын төслүүд хэрэгжүүлэх, гутлын үйлдвэрлэлд байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх зэрэгт анхаарч байна.

Технологи, ногоон хөгжил, тогтвортой байдал нь арьс ширний салбарын 14 дүгээр таван жилийн хөгжлийн гол түлхүүр үгс болж байна. 14 дүгээр таван жилийн төлөвлөгөөнд арьс ширний салбар дараах 10 гол чиглэлээр ажиллана гэж тусгажээ:

1. Хамтын инновацын тогтолцоог бэхжүүлж, бие даасан инновацын чадавхыг хурдан дээшлүүлэх;
2. Өндөр чанарыг суурь болгон баримталж, брэндийг идэвхтэй хөгжүүлэх;
3. Тогтвортой хөгжлийг баримталж, салбарын ногоон үйлдвэрлэлийн түвшнийг дээшлүүлэх;
4. Цахим хөгжлийг хурдасгаж, аж үйлдвэрийн өөрчлөлт, шинэчлэлд хувь нэмэр оруулах;
5. Аж үйлдвэрийн кластеруудын зохион байгуулалтыг сайжруулж, шинэ ухаалаг аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх;
6. Салбарын соёлыг хөгжүүлж, арьс ширний салбарын шинэ имижийг бүрдүүлэх;
7. Шинэ хэрэглээ болон шинэ жижиглэнгийн худалдааг хөгжүүлэх, дотоодын томоохон эргэлтэд бүх талаар нэгдэн орох;
8. Дэлхийн эдийн засгийн тэнцвэрт байдалд идэвхтэй хариу өгч, давхар эргэлтийн загварт тулгуурлан агуулгын өсөлтөд хүрэх;
9. Хүний нөөцийн бүтэц, чанарыг сайжруулж, хүний капиталын чанарыг бүрэн дээшлүүлэх;
10. Интернэт платформыг тасралтгүй бэхжүүлж, салбарын өндөр чанартай хөгжилд үйлчлэх.

3. ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТОЙМ

3.1 ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс 2022 оны байдлаар дэлхийн ноосны хэрэглээний 0.51 хувийг, түүхий арьс ширний 0.03 хувийг, түүхий ноолуурын 45 хувийг хангаж байна. Эсрэгээр БНХАУ дэлхийн ноосны нийт импортын 65.7 хувийг, арьс ширний 15 хувийг эзэлж байгаа нь Монгол Улсыг малын гаралтай түүхий эдийн экспортоо нэмэгдүүлэх газар зүйн таатай байршилд байгааг илтгэж байгаа юм. Гэтэл Монгол Улсын хувьд ноосны үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт угаах үйлдвэр 41 хувь, самнах үйлдвэр 51 хувь, ээрэх 46 хувь, сүлжих, нэхэх үйлдвэр 48 хувь, хивсний үйлдвэр 45 хувь байгаа юм. Харин ноолуурын салбарын хувьд угаасан ноолуурын 70–75 хувийг шууд экспортод гаргадаг бөгөөд угаах, самнах үйлдвэрлэлийн хүчин чадал хангалттай түвшинд байгаа ч ээрмэлийн үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал түүхий эдтэй харьцуулахад 30 орчим хувь байгаа зэрэг асуудлууд хэвээр байгаа юм.

Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, экспортын орлогыг өсгөх, салбарын нэгдсэн стандарт, хууль эрх зүйн орчныг таатай болгох, хүний нөөцийн чадавхыг

нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас «Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай» тогтоолыг 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталж, энэхүү тогтоолын хүрээнд малын гаралтай түүхий эд болох ноос, ноолуур, арьс ширний салбарын үйлдвэрлэлийг цогц байдлаар дэмжих "Цагаан алт" үндэсний хөтөлбөрийг 2024–2028 оны хооронд хэрэгжүүлэхээр болсон.

3.2 ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго нь Монгол Улсын малын гаралтай түүхий эд болох ноос, ноолуур, арьс шир бэлтгэн нийлүүлдэг, түүхий эдийг боловсруулдаг, боловсруулсан түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал, технологийн чанар, борлуулалтын сувгийг дэмжих санхүүжилт олгох, салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог бэхжүүлэх, үйлдвэрлэл, экспорт, борлуулалтыг нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын малын гаралтай түүхий эд боловсруулалтын нэмүү өртгийг нэмэгдүүлж, шинэ түвшинд хүргэхэд оршино.

3.3 ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Хөтөлбөр нь эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд ноос, ноолуур, арьс ширний салбаруудыг дараах үндсэн чиглэлүүдийн дагуу дэмжиж ажиллана.

Үндсэн чиглэл 1. Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Үндсэн чиглэл 2. Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих.

Үндсэн чиглэл 3. Үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх.

Үндсэн чиглэл 4. Салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах

3.4 ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Зорилт 1. Ноолуурын салбарын үйлдвэрлэл, технологи, хүний нөөцийн чадавхыг дэмжих замаар ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 2 дахин нэмэгдүүлэх.

Зорилт 2. Ноосны салбарын үйлдвэрлэл, технологи, хүний нөөцийг чадавхыг дэмжих замаар ноосны салбарын боловсруулалтын түвшнийг 25 хувиас 55 хувь хүртэл нэмэгдүүлэх.

Зорилт 3. Арьс, ширний салбарын үйлдвэрлэл, технологи, хүний нөөцийг чадавхыг дэмжих замаар боловсруулалтын түвшнийг 30 хувиас 50 хувь хүртэл нэмэгдүүлэх.

Зорилт 4. Байгальд ээлтэй, мал аж ахуйд ээлтэй, хэрэглэгчдэд ээлтэй малын гаралтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох зорилтын хүрээнд Био комбинатын үйлдвэрийг бүрэн шинэчилж импортоор авч байгаа 7.5 сая ам.долларын гоц халдварт шүлхий, мялзан, арьс товруутах өвчний вакциныг дотооддоо үйлдвэрлэх.

Зорилт 5. Гарал үүсэл, нийлүүлэлтийн сүлжээний бүрэн мэдээллийн санг бүрдүүлэх биржийн тогтолцоог хөгжүүлж, иргэд, аж ахуйн нэгжид олгох урамшууллын системийг биржээр дамжуулан олгох.


Зорилт 6. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр өрхийн үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл эрхлэх таатай орчныг хангах татвар, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх.

3.5 ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

“Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн нийт төсөв 2.19 их наяд төгрөг бөгөөд үүнээс 682.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Улсын төсвийн санхүүжилт нь зээлийн хүүний дэмжлэг, дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, салбарын стандарт, хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлийн ажлуудад түлхүү зарцуулагдана.

Харин аж ахуйн нэгжүүдэд олгох 1.51 их наяд төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудын эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд Засгийн газрын зүгээс хүүний дэмжлэг үзүүлэх байдлаар хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор шийдсэн.

Зураг 15. “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийн төлөвлөгөө, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

3.6 ЦАГААН АЛТ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

	Ноолуур	Ноос	Арьс шир
Боловсруулалт	20–40%	25–55%	30–50%
Үйлдвэрлэл	1.5 их наяд ₮-2.3 их наяд ₮	240 тэрбум ₮-670 тэрбум ₮	57.8 тэрбум ₮-900 тэрбум ₮
Экспорт	398 сая \$ – 690 сая \$	52 сая \$ – 119 сая \$	9.6 сая \$ – 22.4 сая \$
Ажлын байр	3,000 шинэ ажлын байр	2,200 шинэ ажлын байр	3,000 шинэ ажлын байр

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар


4. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОНОВЧТОЙ ШИЙДЛИЙН ТАЛААРХ САНАЛ

4.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Олон улсын туршлагаас үзэхэд мал аж ахуйн түүхий эдийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж буй улсууд хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хөтөлбөрийн үр ашигтай байдлыг хангахын тулд үйл ажиллагааг бүрэн хариуцсан бие даасан хороо, дэд хороод байгуулдаг байна. Түүнчлэн хорооны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардагдах төсвийг санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгаж явах нь үр дүнтэй байдаг.

Цагаан алт үндэсний хөтөлбөрийн хувьд улсын төсвөөс санхүүжих 682.4 тэрбум төгрөгөөр хөтөлбөрийн үндсэн 4 чиглэлд хийгдэх үйл ажиллагааг санхүүжүүлэхээр байгаа ч хэрэгжүүлэх нэгжүүд нь ХХААХҮЯ, түүний харьяа газрууд болон Сангийн яам байгаа нь хөтөлбөрийг тусгайлан хариуцах бие даасан нэгж бүрдээгүй байгааг илтгэж байна. Зураг 16-д үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын бүтцийн схемийг олон улсын туршлагад нийцүүлэн боловсруулсныг танилцуулж байна.

Зураг 16. Удирдлага, зохион байгуулалтын ерөнхий схем



Цагаан алт үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хороо байх бөгөөд түүний харьяа, ноос, ноолуур, арьс ширний хөтөлбөрийн хэрэгжүүлэх дэд хороодтой байна. Дэд хороо тус бүр (i) Төслийн баг (ii) Техникийн баг (iii) Удирдлагын баг гэсэн бүрэлдэхүүнтэй байх ба эдгээр багууд нь төслийн шалгуур үзүүлэлт тогтоохоос эхлээд төслийн сонгон шалгаруулалт, явцын хяналт, хяналтын тайлан боловсруулах, үр дүнг тайлагнах зэрэг үүргүүдийг гүйцэтгэснээр хөтөлбөрийн үр ашгийг цаг алдалгүй хянах, сайжруулах боломж бүрдэх юм.

4.2 ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ САНАЛ

Санхүүжилтийн хэмжээ: Монгол Улсын төсвөөс санхүүжих 682 тэрбум төгрөгийн санхүүжилт нь хөтөлбөрийн үндсэн 4 чиглэлийн дагуух дэд бүтэц, стандарт сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх болон хүүний дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулагдахаар батлагдсан. Үүнээс хүүний дэмжлэгт 2024 онд нийт 23.5 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн. Арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх 1.5 их наяд төгрөгийг 5 жилийн хугацаанд жил бүр 300 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөгөөнд тусгаад байгаа бөгөөд үүнээс 250 тэрбум төгрөгийг ноос, ноолуурын салбарт, 50 тэрбум төгрөгийг арьс ширний салбарт олгохоор тогтсон.


Санхүүжилтийн хүү: Засгийн газар арилжааны банкуудад хүүний дэмжлэг үзүүлэх замаар салбаруудад олгох санхүүжилтийг хөнгөлөлттэй хүүтэй олгохоор зорьж байгаа. ХХААХҮЯ-ны мэдээлснээр Засгийн газрын төсөвт суулгасан хүүний дэмжлэг нь аж ахуйн нэгжид очих санхүүжилтийн зардлын 11–12 орчим хувийг төлөх боломжтой байдлаар тооцоолсон. 2024 оны 8 дугаар сарын байдлаар банкны салбарын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.4 хувь байгаа бөгөөд үүний 11–12 хувийг татаас байдлаар олговол хөтөлбөрийн санхүүжилтийн хүү **4.4–5.4** хувийн хооронд байх боломжтой байна.

Санхүүжилтийн хугацаа: Ноос, ноолуур болон арьс ширний салбарын эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ нь салбарын түүхий эд бэлтгэлийн онцлогоос хамаарч хугацааны хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийн эрэлт 1–3 дугаар сарын хооронд өндөр байдаг бол арьс ширний салбарын хувьд 4–11 дүгээр сарын хооронд байдаг. Эрэлт өндөр саруудад багтаж санхүүжилтээ авснаар аж ахуйн нэгжүүдийн дараагийн шатны боловсруулалтыг цаг тухайд нь явуулах боломж бүрддэг. Түүнчлэн, өмнө хэрэгжиж байсан хөтөлбөрүүд эргэлтийн хөрөнгийн зээлийг 1 жил хүртэлх хугацаагаар олгож байсан нь үйлдвэрүүдийг эргэн төлөлтийн дарамтад хурдан оруулж улмаар нэмүү өртөг шингээх боломжийг бууруулж байсан. Иймд санхүүжилтийн хугацааг эргэлтийн хөрөнгийн хувьд **2 жил буюу түүнээс дээш**, хөрөнгө оруулалтын зээлийн хувьд **4 жил буюу түүнээс дээш** байх нь зүйтэй гэж үзэж байна.

Хүү тогтооход анхаарах зүйлс: Хөтөлбөр хэрэгжих хугацаа нь 2028 он хүртэл байх тул хөтөлбөрийн хугацаанд бодлогын хүүнээс хамаарч өөрчлөлт орох тохиолдолд анхны гэрээнд зурагдсан хүү болон тухайн үеийн зах зээлийн хүүний зөрүүнээс үүсэх эерэг болон сөрөг төлөх татаасны хэмжээг анхаарах буюу хүүний түвшинг бодлогын хүүтэй нийцтэй байдлаар тогтоож явах хэрэгтэй. 2024 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбарын ногоон зээлийн дундаж хүү 14.4 хувь байгаа тул хэрэв хөтөлбөрийн зээлийг ногоон зээлийн санхүүжилтээр авах тохиолдолд хүүний дэмжлэгийн дараах зөрүүг 2 хувиас дээш хэтрүүлэхгүй байх нь зүйтэй байна.

Хоёр шатлалт санхүүжилтийн схем: Олон улсын туршлагаас харахад зээлийн санхүүжилтийг зориулалтын дагуу ашиглах, зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн төслийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёр шатлалт зээл олголтын хувилбарыг түлхүү ашигладаг байна. Иймд хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо Зураг 17-д тусгасан байдлаар явуулах нь хөтөлбөр хэрэгжих 5 жилийн хугацаанд салбар тус бүрийн аж ахуйн нэгжүүд тодорхой шалгууруудыг хангаснаар эргэлтийн хөрөнгийн зээлд дахин хамрагдах боломж бүрдэх юм. Шалгуурын хувьд схемд тусгасны дагуу хөтөлбөрийн үндсэн чиглэлийн хүрээнд санхүүжилтээ зориулалтын дагуу ашигласан, үйлдвэрлэлийн стандартаа сайжруулсан, байгальд ээлтэй, дахин ашиглах боломжтой технологи нэвтрүүлсэн, түүхий эдийн худалдан авалтаас эхлээд үйлдвэрийн шат дамжлага бүрийн хувьд бүрэн мэдээллийг цахим системд бүртгэсэн зэрэг ерөнхий шалгууруудын хүрээнд салбар тус бүрийн нарийвчилсан шалгуур тогтоох нь зүйтэй.

Зураг 17. Санхүүжилтийн ерөнхий схемийн санал



Барьцаа хөрөнгийн уян хатан байдал: Ноолуур болон арьс ширний салбарт үйл ажиллагаа аж ахуйн нэгжүүдэд зээл олгоходоо арилжааны банкуудтай барьцаа хөрөнгийн уян хатан байдлын талаар хэлэлцээр хийж, тоног төхөөрөмж, агуулахад байгаа бэлэн бүтээгдэхүүн зэргийг барьцаа хөрөнгийн үнэлгээнд оруулах боломжийг бүрдүүлснээр оновчтой санхүүжилтийн түвшинд хүрэх, санхүүжилтийн потенциалыг нэмэгдүүлэх боломжтой.

Хоёр шатлалт зээл олголтын систем: Цагаан алт үндэсний хөтөлбөрийн хүрээнд олгогдох зээлийн хувьд зориулалтын дагуу ашиглах байдлыг энэхүү зарчмаар нэмэгдүүлэх боломжтой юм.

4.3 НООЛУУРЫН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН СХЕМ

Ноолуурын салбарын хувьд эргэлтийн хөрөнгийн дутагдал хамгийн өндөр хэсэг нь нэхмэл, ээрмэлийн үйлдвэрүүд буюу түүхий эд нөөцөлж авдаг аж ахуйн нэгжүүд юм. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд тухайн оны **эхний 3 сард багтан 2 жилийн хугацаатай** хөнгөлөлттэй хүүтэй зээлийн санхүүжилтийг олгосноор түүхий ноолуурын татан авалтаа цаг алдалгүй хийж, дараагийн шатны боловсруулалтын гарц нэмэгдэнэ.

Хүснэгт 4. Ноос, ноолуурын салбарт олгох санхүүжилтийн ерөнхий нөхцөл

Санхүүжилтийн төрөл	Хугацаа	Хүү	Санхүүжилтэд түлхүү хамрагдах хэсэг	Олгох хугацаа
Эргэлтийн хөрөнгийн зээл	2 жил	4.4–5.4% (Хүүний дэмжлэгийн дараах хэмжээ)	Нэхмэл, ээрмэлийн үйлдвэрүүд	Оны эхний 3 сард багтааж олгох
Хөрөнгө оруулалтын зээл	4 жил	4.4–5.4% (Хүүний дэмжлэгийн дараах хэмжээ)	Ээрмэлийн үйлдвэрүүд	Жилийн турш


Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хөрөнгө оруулалтын зээл хамгийн их дутагдалтай хэсэг нь ээрмэлийн үйлдвэрүүд байдаг бөгөөд одоогийн байдлаар үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгө оруулалтаа олон улсын санхүүгийн байгууллагуудаас өндөр хүүтэй зээлээр санхүүжүүлж байна. Иймд санхүүжилтийн хугацааг **4 жил буюу түүнээс дээш**, хүүний түвшинг хөнгөлөлттэй байдлаар шийдсэнээр ээрэх үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлыг 40 хувьд хүргэх улмаар эцсийн бүтээгдэхүүн боловсруулалтын түвшинг урт хугацаанд тогтвортой өсгөх боломж бүрдэнэ.

Эргэлтийн хөрөнгийн зээл нь 2 жилийн хугацаатай тохиолдолд хөтөлбөрийн хугацаанд аж ахуйн нэгжүүд 2 удаа хамрагдах боломжтой тул дахин хамрагдах хүсэлтэй аж ахуйн нэгжүүдэд Зураг

18-д үзүүлсний дагуу шалгууруудыг тавьж өгснөөр давхар мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цахим мэдээллийн талбарыг хөгжүүлэх, зээлийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Зураг 18. Ноолуурын салбарт олгох санхүүжилтийн схем



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

4.4 НООСНЫ САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН СХЕМ

Ноосны салбарын хувьд эргэлтийн хөрөнгийн дутагдал хамгийн өндөр хэсэг нь ноолуурын салбартай ижил буюу нэхмэл, ээрмэлийн үйлдвэрүүд байдаг. Үйлдвэрлэлийн шат дамжлагын хувьд ноолуурын салбартай ижил байдаг бөгөөд эдгээр аж ахуйн нэгжүүдэд **2 жилийн хугацаатай** хөнгөлөлттэй хүүтэй зээлийн санхүүжилтийг олгосноор түүхий ноолуурын татан авалтаа цаг алдалгүй хийж, дараагийн шатны боловсруулалтын гарц нэмэгдэнэ.

Хүснэгт 5. Ноос, ноолуурын салбарт олгох санхүүжилтийн ерөнхий нөхцөл

Санхүүжилтийн төрөл	Хугацаа	Хүү	Санхүүжилтэд түлхүү хамрагдах хэсэг	Олгох хугацаа
Эргэлтийн хөрөнгийн зээл	2 жил	4.4–5.4% (Хүүний дэмжлэгийн дараах хэмжээ)	Нэхмэл, ээрмэлийн үйлдвэрүүд	Жилийн турш
Хөрөнгө оруулалтын зээл	4 жил	4.4–5.4% (Хүүний дэмжлэгийн дараах хэмжээ)	Ээрмэлийн үйлдвэрүүд	Жилийн турш

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

4.5 АРЬС ШИРНИЙ САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН СХЕМ

Арьс ширний салбарын хувьд эргэлтийн хөрөнгийн дутагдал боловсруулах үйлдвэр болон арьсан эдлэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түвшинд илүү өндөр байна. Боловсруулах үйлдвэрүүдийн хувьд дулааны улиралд химийн орцын татан авалт хийх (4–8 сар), намрын улиралд түүхий эдийн бэлтгэл хийх (8–11 сар) үеүдэд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн эрэлт хамгийн өндөр болдог. Харин хөрөнгө оруулалтын зээлийн хувьд арьс ширний салбарын үйлдвэрлэлийн бүх шатанд хэрэгцээтэй байсаар байна. Хүснэгт 6-д санхүүжилтийн ерөнхий нөхцөл, зураг 19-д санхүүжилтийн схемийн ерөнхий саналыг тусгав.

Хүснэгт 6. Арьс ширний салбарт олгох санхүүжилтийн ерөнхий нөхцөл

Санхүүжилтийн төрөл	Хугацаа	Хүү	Санхүүжилтэд түлхүү хамрагдах хэсэг	Олгох хугацаа
Эргэлтийн хөрөнгийн зээл	2 жил	4.4–5.4% (Хүүний дэмжлэгийн дараах хэмжээ)	Боловсруулах үйлдвэр, арьсан эдлэлийн ЖДҮ	Намрын түүхий эд бэлтгэл болон химийн орцын татан авалтаас өмнө
Хөрөнгө оруулалтын зээл	4 жил	4.4–5.4% (Хүүний дэмжлэгийн дараах хэмжээ)	Боловсруулах үйлдвэр, арьсан эдлэлийн ААН-үүд	Жилийн турш


Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Арьс ширний салбарт олгох санхүүжилтийн хувьд хүүний хөнгөлөлттэй түвшин 4.4–5.4 хувь буюу дээрх хоёр салбартай ижил байх хэдий ч химийн орцын татан авалт, тоног төхөөрөмж захиалах зэрэгт хугацаа их шаардагддаг гэх мэдээллийг Арьс ширний холбоотой хийсэн уулзалтын үеэр дурдсан. Иймд энэ салбарт олгох эргэлтийн хөрөнгийн зээлийг эхний жил үндсэн төлбөрөөс чөлөөлөх, арьсан

эдлэлийн ЖДҮ эрхлэгч нарт Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан авах боломжийг нээлттэй байлгах зэрэг зохицуулалтыг хийж өгөх нь зүйтэй гэж үзэж байна (Зураг 19).

Эргэлтийн хөрөнгийн зээл нь 2 жилийн хугацаатай тохиолдолд хөтөлбөрийн хугацаанд аж ахуйн нэгжүүд 2 удаа хамрагдах боломжтой тул дахин хамрагдах хүсэлтэй аж ахуйн нэгжүүдэд Зураг 19-д үзүүлсний дагуу шалгууруудыг тавьж өгснөөр давхар мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цахим мэдээллийн талбарыг хөгжүүлэх, зээлийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Зураг 19. Арьс ширний салбарт олгох санхүүжилтийн схем



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Australian Wool Sustainability Scheme. (n.d). *ResponsiWOOL growers*. Australian Wool Sustainability Scheme: <https://www.australianwoolsustainability.com.au/About/ResponsiWOOLGrowers/>-ээс гаргасан
- China National Textile and Apparel Council (CNTAC). (n.d). *Wool prices statistics*. China National Textile and Apparel Council (CNTAC): <https://www.cntac.org.cn>-ээс гаргасан
- International Wool Textile Organisation. (n.d). *A Compilation of Wool Industry Statistics*. International Wool Textile Organisation.-ээс гаргасан
- Ministry of Textiles. (2021). *Integrated Wool Development Programme (IWDP) for implementation during 2021-22 to 2025-26: Approved guidelines*. Ministry of Textiles, India: https://woolboard.nic.in/Download/Guidelines_ProjectProposal.pdf-ээс гаргасан
- National Development and Reform Commission of China. (2022). *China's 14th Five-Year Plan for economic and social development*. National Development and Reform Commission of China: <https://en.ndrc.gov.cn/policies/202203/P020220315511326748336748336.pdf>-ээс гаргасан
- Selina Wamucii. (n.d). *World Leather Prices*. Selina Wamucii: <https://www.selinawamucii.com/leather/>-ээс гаргасан
- Гаалийн Ерөнхий Газар. (2015–2013). Статистикийн эмхэтгэл.
- Үндэсний Статистикийн Хороо. (2023). *Экспортын зарим гол нэрийн барааны тоо хэмжээ болон үнийн дүн, сараар (өссөн дүн)*. Үндэсний Статистикийн Хороо: <https://1212.mn/>-ээс гаргасан
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Монголын ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарын танилцуулга.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Ноос бэлтгэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт.
- Эрхэмбаяр, Б., Янжинлхам, Н. (2023). Монгол Улсын ноолуурын салбарын төлөв байдал. *Мөнгө, санхүү баялаг сэтгүүл*.

